



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/555

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалт, "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн 3 дугаар зүйлийн 3.3.5, 3.4.5 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 39 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн Засаг даргын нэрэмжит үндэсний бичгийн олимпиад, "Үндэсний бичигтэн аймаг" болох аяны хүрээнд "Шилдэг сум, байгууллага" шалгаруулах арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 13,600,00 (арван гурван сая зургаан зуун мянга) төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн батлагдсан зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаж ажиллахыг Боловсролын газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

4. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Отгонбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4 doc

0231301913

Аймгийн засаг даргын 2021 оны
 111 дугаар сарын 16-ны өдрийн А/1555 дүгээр
 захирамжийн нэгдүгээр
 хавсралт

ДИОА0042

Говь-Алтай аймгийн төрийн албан хаагч, иргэдийн дунд зохион байгуулах монгол
 бичгийн олимпиадын төсвийн зардлын тооцоо

Д.д	Үйл ажиллагаа	Хамрах хүрээ	Шаардагдах хөрөнгө	Тайлбар
1	Олимпиадын шагнал	Төрийн албан хаагч	1,9 сая төгрөг	I байр – 0,5 сая төгрөг II байр – 0,5 сая төгрөг III байр – 0,4 сая төгрөг Тусгай байр -2. Тус бүр 200,000 төгрөг Өргөмжлөл 100,000 төгрөг Дурсгалын зүйл-200,000 төгрөг
2	Олимпиадын шагнал	Иргэд	1,6 сая төгрөг	I байр – 0,5 сая төгрөг II байр – 0,4 сая төгрөг III байр – 0,2 сая төгрөг Тусгай байр -2. Тус бүр 200,000 төгрөг Өргөмжлөл 100,000 төгрөг Дурсгалын зүйл-200,000 төгрөг
3	Талархал	2-р шатанд шалгарсан оролцогчид	0,5 сая төгрөг	Сум, байгууллага, хамт олноосоо шалгарсан 2-р шатны оролцогчдод талархал, дурсгалын зүйл худалдаж авах
4	Үйл ажиллагааны зардал	Засалтын комисс	0,3 сая төгрөг	Олимпиадын материал бэлтгүүлэх, засах,
5	Бичиг хэргийн зардал		0,7 сая төгрөг	Бичгийн цаас, хэвлэл, урилга
			Нийт	5.000.000

**“Үндэсний бичигтэн сум, байгууллага” шалгаруулах
уралдааны шагналын зардлын тооцоо**

№	Шагналын нэр	Байр	Тоо ширхэг	Үнэ	Хариуцах эзэн
1	Гэрч бичиг “Үндэсний бичигтэн сум”	Нэгдүгээр байр (100×60) өргөмжлөл	1	65000	“Үндэсний бичигтэн сум, байгууллага” шалгаруулах ажлын хэсэг.
		Мөнгөн урамшуулал	3,000,000		
		Дурсгалын зүйл	100,000		
		Хоёрдугаар байр (100×60) өргөмжлөл	1	65000	
		Мөнгөн урамшуулал	1,170,000		
		Дурсгалын зүйл	100,000		
		Гуравдугаар байр (100×60) өргөмжлөл	1	65000	
		Мөнгөн урамшуулал	870,000		
		Дурсгалын зүйл	100,000		
		Тусгай байр (70×30)	2	90000	
		Дурсгалын зүйл	2	100,000	
		Тусгай байр Мөнгөн урамшуулал	2	200,000	
		Нэгдүгээр байр (100×60) өргөмжлөл	1	65000	

2	Гэрч бичиг "Үндэсний бичигтэн байгууллага"	Мөнгөн урамшуулал	500,000	
		Дурсгалын зүйл	100,000	
		Хоёрдугаар байр (100×60) өргөмжлөл	1	65000
		Мөнгөн урамшуулал	700,000	
		Дурсгалын зүйл	100,000	
		Гуравдугаар байр (100×60) өргөмжлөл	1	65000
		Мөнгөн урамшуулал	300,000	
		Дурсгалын зүйл	100,000	
		Тусгай байр Мөнгөн урамшуулал	2	450,000
		Дурсгалын зүйл	2	100,000
		3	Бусад зардал	230,000
			Нийт	8.600.000

оОо